



АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 3/80

Улаанбаатар хот

Тэтгэмж олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.10, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.2, Эх, эцэг олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.8 дахь заалт, Амгалан дулааны станц ТӨХК-ийн Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд 2021-2022 онд хэрэгжүүлэхээр байгуулсан Хамтын гэрээний 6 дугаар зүйлийн 6.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Өрх толгойлсон эх, эцэгүүдийн өрхийн орлогыг дэмжих зорилгоор Хяналтын хэлтсийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженер Андрейгийн Энхжаргал, Инженерийн хэсгийн Горимын хяналт, тооцооны инженер Сумъяагийн Нарантуяа, Хангамжийн хэлтсийн Угаалгын машины оператор Магсаржамцын Оюунгэрэл, Санхүү эдийн засгийн хэлтсийн Үндсэн хөрөнгийн нягтлан бодогч Наранчулууны Нэргүй, Нэгдсэн цехийн Цахилгааны хэсгийн Цахилгаанчин Лхагвасүрэнгийн Пүрэврагчаа нарт тус бүр 672,000 (Зургаан зуун далан хоёр мянга)-н төгрөг, Зуухан цехийн Зуухны машинч Гансүхын Болортуяа, Санхүү, эдийн засгийн хэлтсийн Эдийн засагч Энхболдын Болортуяа, Нэгдсэн цехийн Хими хэсгийн Түлшний лаборант Насанбуянгийн Ариунжаргал нарт тус бүр 420,000 (Дөрвөн зуун хорин мянга)-н төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг тус тус олгосугай.

2. Дээрх ажилтнуудад олгох тэтгэмжийг нийгмийн зардлын сангаас олгохыг Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогчийн ажил үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ө.Удвал)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс (Б.Ган-Очир)-т даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ш.БАЯНМӨНХ